

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлыг тооцох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын дарга нарт, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар (Б.Баярсайхан)-т, бүх шатны дарга нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүлийн бодлогын газар (Ц.Мөнхзул)-т, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Д.Ренчиндорж)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/150 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Т.АУБАКИР

ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн (цаашид “хохирогч” гэх) амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төсвийг нэг хүнд ногдох хувьсах зардал (цаашид “хувьсах зардал” гэх)-аар тооцоход энэхүү журмыг баримтална.

1.2.Энэхүү журам нь түр хамгаалах байр, 24 цагийн ажиллагаатай нэг цэгийн үйлчилгээний төвд хамаарна.

Хоёр. Хувьсах зардлын бүрэлдэхүүн

2.1.Хувьсах зардлын бүрэлдэхүүнд дараах бараа, үйлчилгээг хамааруулна:

- 2.1.1.хоол хүнс;
- 2.1.2.ариун цэврийн хэрэгсэл;
- 2.1.3.хувцас;
- 2.1.4.төлбөртэй тусламж үйлчилгээ.

2.2.Дараах зардлыг хувьсах зардлын бүрэлдэхүүнд оруулж тооцохгүй. Үүнд:

2.2.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.8-д бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээ;

2.2.2.Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг хариуцах эмчилгээ үйлчилгээ;

2.2.3.Нийгмийн халамжийн үйлчилгээ;

2.2.4.Түр хамгаалах байр, 24 цагийн ажиллагаатай нэг цэгийн үйлчилгээний ажилтны цалин хөлс, урамшуулал болон байрын ашиглалтын тогтмол зардлыг хувьсах зардлын бүрэлдэхүүнд оруулахгүй.

Гурав. Хувьсах зардлыг тооцох

3.1.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх хоногийн дээд хязгаар **20** хоног байна.

3.2.Хоол хүнсний зардлыг түр хамгаалах байранд байрласан хоногийн тоогоор үржүүлж тооцно.

Тайлбар:“Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай” Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан илчлэг, орц, нормыг хангахуйц өглөөний цай, өдрийн болон оройн хоол байна.

3.3.Ариун цэврийн хэрэгслийн зардлыг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамрагдсан хохирогч бүрд нэг удаа олгох бөгөөд хувийн ариун цэврийн хэрэгслийн багцын үнэ нь энэ журмын хавсралтад заасан дээд хязгаараас хэтрэхгүй байна.

Тайлбар: Ариун цэврийн хэрэгслийн багцад шүдний оо, сойз, гар нүүрийн алчуур, гарын болон эдийн саван, шампунь, ариун цэврийн цаас, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэглэл, эмнэлгийн анхан шатны тусламжид шаардагдах эм, хэрэглэл (өвчин намдаах эм, лаа, боолт, ариутгалын бодис) зэрэг бараа бүтээгдэхүүн орно.

3.4.Хувцасны зардлыг хохирогчид зайлшгүй хэрэгцээтэй гадуур болон дотуур хувцас, гутлын нэр төрөл, зардлын хэмжээ энэ журмын хавсралтад заасан дээд хязгаараас хэтрэхгүй байна.

3.5.Хохирогчид үзүүлэх дараах төлбөртэй тусламж үйлчилгээнээс хохирогчид чиглэсэн төлөвлөгөөнд үндэслэн сонгох ба үзүүлэх үйлчилгээний давтамж болон зардлын хэмжээ нь энэ журмын хавсралтад заасан дээд хязгаараас хэтрэхгүй байна.

3.5.1.холбон зуучлах;

3.5.2.бичиг баримтжуулах;

3.5.3.сэтгэл зүйн үйлчилгээ;

3.5.4.эрх зүйн үйлчилгээ;

3.5.5.тээврийн хэрэгслээр үйлчлэх;

3.5.6.харилцаа холбоогоор үйлчлэх;

3.5.7.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

3.5.8.ялгаатай хэрэгцээнд суурилсан тусламж, үйлчилгээ.

3.6.Хүүхдийг түр хамгаалах байранд хүлээн авсан тохиолдолд түүний зардлыг "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал"-ын дагуу "Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив"-ыг баримтлан санхүүжүүлнэ.

Дөрөв. Бусад

4.1.Хувьсах зардлын жилийн хэрэгцээг тооцохдоо түр хамгаалан байрлуулан байрлуулах үйлчилгээнд хамрагдаж үйлчилгээ авсан хохирогчдын сүүлийн 3 жилийн дунджаар тооцож, шаардагдах зардлыг төсөвт тусгуулахаар холбогдох байгууллагад саналаа хүргүүлнэ.

4.2. Хувьсах зардлыг тооцоход ашиглах тоо баримтууд албан ёсны мэдээ, тайлан, статистик болон төлбөрийн баримтаар нотлогдсон байна.

4.3. Энэ журмын хавсралтаар баталсан зардлын дээд хязгаарыг гурван жил тутамд нэг удаа шинэчилнэ.

---oOo---

Түр хамгаалан байрлуулах
үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах
зардал тооцох журмын хавсралт

ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗАРДЛЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ДЭЭД ХЯЗГААР

Хүснэгт 1. Хоол хүнсний зардлын дээд хязгаар

№	Нэр төрөл	Нэг хоногт ногдох зардлын дээд хэмжээ
1	Хоол хүнс	10,000

Хүснэгт 2. Ариун цэврийн хэрэгслийн зардлын дээд хязгаар

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Багцын үнэ
1	Ариун цэврийн хэрэгслийн багц	1 удаа	35,000

Хүснэгт 3. Хувцасны зардлын дээд хязгаар

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Өвлийн хувцас	1	200,000
2	Хавар, намрын хувцас	1	150,000
3	Дотуур хувцас	1	25,000

Хүснэгт 4. Төлбөртэй тусламж үйлчилгээний зардлын дээд хязгаар

№	Нэр төрөл	Тоо хэмжээ давамж	Нийт үнэ
1	Холбон зуучлах	1-3	10,000
2	Харилцаа холбоогоор үйлчлэх	2	4,000
3	Бичиг баримтжуулах	1-2	Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсийг баримтална
4	Тээвэрлэх	2	10,000
5	Сэтгэлзүйн үйлчилгээ	2-4	24,000
6	Эрх зүйн үйлчилгээ	2-4	24,000
7	Эрүүл мэндийн үйлчилгээ	1-2	Эрүүл мэндийн үйлчилгээний үнэ хөлсийг баримтална
8	Ялгаатай хэрэгцээнд тулгуурласан тусламж	1	35,600

ТАНИЛЦУУЛГА

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам"-ын тухай

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагын харьяанд байгуулсан түр хамгаалах байрыг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн харьяаллаар ажиллуулж байна.

Түр хамгаалах байрууд нь үйл ажиллагаандаа “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019” Монгол Улсын стандарт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.

Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байр 22, нэг цэгийн үйлчилгээний 17 төв үйл ажиллагаа явуулж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан 7 төрлийн тусламж, үйлчилгээг 2025 оны хагас жилийн байдлаар 1212 хүүхэд, 864 насанд хүрэгчид үзүүлж, нийт 2076 иргэний аюулгүй байдлыг хангасан. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд урт хугацааны үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн 1 Түр хамгаалах байр ажиллаж байна.

- ❖ Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд 1058 хүүхэд, 817 иргэн
 - ❖ Сэтгэл зүйн үйлчилгээнд 725 хүүхэд, 387 иргэн
 - ❖ Эрх зүйн туслалцаа 305 хүүхэд, 180 иргэн
 - ❖ Боловсролын үйлчилгээ 604 хүүхэд
 - ❖ Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд 466 хүүхэд, 337 иргэн
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд 45 иргэн тус тус хамрагдсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-т “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох бөгөөд хувьсах зардлыг тооцох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасныг үндэслэн “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар баталсан.

Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай уялдуулан “Аргачлал, зардлын норматив батлах тухай” Засгийн газрын 2024 оны 236 дугаар тогтоолын хавсралтаар "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал", "Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив"-ыг баталсан.

Иймд түр хамгаалах байрны хамгаалалтад авах хүүхдэд зарцуулах зардлын нормативын уялдааг хангах, бараа, ажил, үйлчилгээний үнийн өөрчлөлт зэрэгтэй уялдуулан журмаар тогтоосон хувьсах зардлын тарифыг шинэчлэх зайлшгүй шаардлага бий болж байна.

Дээрх үндэслэлээр түр хамгаалах байрны нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журамд дараах өөрчлөлтүүдийг тусгав. Үүнд:

- 0-18 хүртэлх насны хүүхдийн Хүүхдийг түр хамгаалах байранд хүлээн авсан тохиолдолд түүний зардлыг "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал"-ын дагуу "Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив"-ыг баримтлан санхүүжүүлэх;
- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх хоногийн дээд хязгаарыг 20 хоног хүртэл байхаар нэмэгдүүлэх;
- Хоол хүнсний болон холбогдох зардлуудын хэмжээг нэмэгдүүлж, зах зээлийн үнээр тооцдог болох зэрэг зохицуулалтыг тусгалаа.

Энэ журам батлагдсанаар түр хамгаалах байраар үйлчлүүлэх шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, хамгааллын тогтолцоо сайжирна гэж үзэж байна.

